


Living the LOTUS

Buddhism in Everyday Life

4
2018

VOL. 151



 **Үүсгэн байгуулагчийн сургаал**



Хүнд таалагдахын тулд

Хавар 4 сард сургууль, ажил эхэлдэг тул шинэ учрал олон байдаг. Ялангуяа залуучууд дунд шинэ ажлын дарга, хамт олонтой хэрхэн харилцахаа мэдэхгүй “яаж таалагдах вэ” хэмээн шаналах хүн байгаа байх. Хүнд таалагдах хамгийн найдвартай арга бол өөрөө нөгөө хүндээ чин сэтгэлээсээ дуртай болох юм.

“Намайг яагаад хүн тоодоггүй юм бол” гэж шаналах хүн бас байдаг. Тийм хүн яаж өөрийгөө гоё сайхан харагдуулах вэ гэдэгт л санаа зовдог. Хэлбэрдэж, мундаг зүйл л яриад байхаас биш таалагдах гэж байгаа нөгөө хүнээ жоохон ч ажигладаггүй. Ингэж байснаас өөрөө нөгөө

хүндээ дуртай болсон нь хурдан. Хүн гэдэг өөрт нь сайн хүнд аяндаа дуртай болдог жамтай.

Цагаан лянхуа сударт 33 дүрээр илрэн гарч ирж, бүх хүмүүсийг заавал авардаг Арьявал бодисадва гардаг. Арьявал бодисадва японоор “Канзэнон” гэдэг ба энэ нь хүмүүсийн сэтгэл, хүслийг сайн ойлгодог гэсэн утгатай.

“Би ярихдаа муу болохоор ойлгомжтой хэлж чадахгүй байх” гээд бууж өгдөг хүн байдаг боловч их ярихаас илүү их сонсож нөгөө хүнээ ойлгох нь чухал. Хэн нэгний яриаг сонсохдоо дотночилон чих тавин сонсдог болох юм бол ямар ч хүнд таалагдах болно.

Living the Lotus
Vol. 151 (2018.04)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг тууцгаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Төгс хүн болох

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Мэндчилэх төдийд

Нэгэн албан газар өглөө ажлынхантайгаа тун хүндэтгэлтэй мэндэлдэг хүн байжээ. Нөгөө хүнийхээ царайг сайтар харангаа “өглөөний мэнд хүргэе” гэж хэлээд, толгойгоо удаан гэгч нь бөхийлгөнө. Ердөө үүнийг л хийдэг байсан боловч өглөө ажил эхлэх гээд бужигнаж байхад ингэж хэт хүндэтгэлтэй мэндлэхээр дургүйцэх хүн ч байв.

Гэхдээ хэсэг хугацааны дараа албан газрын уур амьсгал өөрчлөгдөж иржээ. Өмнө нь хажуугаар зөрөх хүнтэй “сайн уу” гээд л өнгөрдөг байсан хүмүүс хүнтэй мэндлэхдээ нөгөө хүнийхээ өдөөс эгц харж байгаад мэндэлдэг болж, улмаар албан газрын уур амьсгал зөөлөн болсон байна.

Төгс гэдэг нь зан чанар “бүрэн төгс, дутагдалгүй” байхыг хэлнэ. Тэгэхээр “төгс хүн болох” гэдэг нь хүний дээдэд ойртох буюу бурханы шавь бидний хувьд бол Бурхан багш шиг хүн болохыг хэлнэ. Гэхдээ энэ нь тийм хол зорилго биш гэж бодож байна.

Бурхан, бодисадва нь хүнд амар амгалан, сэтгэл хангалуун байдлыг мэдрүүлж, түүгээр дамжуулж нөгөө хүнд “хүнтэй эвтэй сайхан байх юмсан” гэсэн сэтгэлийг төрүүлж, тухайн газар эв нэгдлийг бий болгодог. Ингээд бодоод үзэхээр өглөөний ганцхан мэндчилгээгээр хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, албан газрын уур амьсгалыг зөөлөн болгосон хүн ч гэсэн төгс хүн юм. Хүмүүс бидэнд дутагдалтай тал олон байдаг ч гэсэн ийнхүү хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөсөн нь бүх хүнд бурханлаг чанар байдгийг илтгэнэ. Тэгэхээр энэ хавар шинэ хүмүүстэй уулзаж танилцахдаа сайхан харилцааг бий болгох түлхүүр бол мэндчилгээгээр дамжуулж хүмүүсийн бурханлаг чанарт мөргөх явдал гэж хэлж болно.

Бусдын зовлонг ойлгодог хүн больё

Хүний жинхэнэ мөн чанар бол бурханлаг чанар гэх юмуу төгс зан чанарын талаар өөр олон яриа байдаг.

Эдогийн үе (1603-1868)-д одоогийн Нара мужийн Ёшино хотод хүнлэг мөн чанараараа алдаршсан Сэйкүроо хэмээх буддын Жёодоо урсгалын сүсэгтэн амьдардаг байсан гэдэг.

Тэрээр гэрээсээ мөнгөө хулгайд алдаад ийнхүү хэлжээ: “Над шиг юу ч үгүй хүний гэрт хулгай хийхээр орж ирснийг бодвол их л ядарсан хүн байж дээ. Ашгүй мөнгө байж таараад тэр хүн мөнгөтэй болсонд баярлаж байна.” Түүнчлэн “Би яг одоо Бурханы тааллаар «мөнгөө алдах хүн» болсон тул үүн шиг сайхан зүйл алга” гэж хэлж байжээ.

Мөн адил хүндэг чанараараа алдаршсан Жёодоо урсгалын сүсэгтэн Оосака хотын Моноданэ Кичибээ гуай “Сайхан үед бол хэн ч баяртай байдаг. Гэхдээ зовлон бэрхшээлийн цаана бурханы сургаал оршдог” хэмээсэн байдаг. Үүгээр дамжуулж бэрхшээлээр дамжуулж “талархах сэтгэл”-ийг ухаарсан баяр хөөр нь юунаас ч илүү баяр хөөр бөгөөд сүсэг бишрэлийн үнэ цэнэ үүнд байдгийг сургасан байна.

Ийм хүмүүс Бурханы ачаар амьд яваадаа талархах сэтгэл, энэрэнгүй нигүүлсэнгүйн сэтгэлээр дүүрэн байдаг. Тэгэхээр төгс зан чанар гэдэг нь нөгөөтэйгүүр ямар ч зүйлийг талархах сэтгэлээр хүлээн авч, сэтгэл хангалуун уужуу байхыг хэлж болох юм.

Дээр дурьдсан Сэйкүроо гуай аавыгаа эрт алдаж, ээжтэйгээ ядуу зүдүү амьдардаг байсан ба 33 настайд нь эхнэр нь өөд болжээ. Тэрээр амьдралын гашуун зовлонг хангалттай эдэлсэн болохоор л хүний сэтгэлийн зовлонг ойлгож, тэндээс ундрэн гарах нигүүлсэхүйн сэтгэл нь аяндаа хүмүүсийг аврах билиг оюун болж хувирсан биз ээ.

Шүүмжлэгч Камэи Кацүичироо (1907-1966) зөөлөн инээмсэглэлээрээ олонд танигдсан Нара хотын Чюүгүүжи хийдийн Нэг хөлөө ачиж суусан Жанрайсиг бодисадвагийн үл ялиг инээмсэглэл тодруулсан дүрийг хараад гүнзгий гашуудал, гунигаас үүдсэн “цурхиран уйлах дүр зураг байж болох юм” хэмээсэн байдаг. Өөрөөр хэлбэл бодисадвагийн сэтгэлийн гүнд үгээр илэрхийлэхийн аргагүй гүн гүнзгий зовнил байдаг хэмээжээ.

Шагжамүни бурхан ч тэр, хүмүүс бид нар ч гэсэн энэрэнгүй нигүүлсэхүйн сэтгэл ба билиг оюунаа хүмүүсийн тусын тулд бүрэн дүүрэн гаргахын төлөө энэ ертөнцөд өөрсдөө хүсэж төрсөн гэдэг билээ.

“Косей” сэтгүүл 4-р сарын дугаараас



The 7 Parables of the Lotus Sutra

Оройн Дээд
Цагаан Лянхуа Судар



Энгэрт нуусан эрдэнийн үлгэр

8-р бүлэг: Таван зуун шавь
нарын эш авсныг үгүүлэх

Нэгэн ядуу эр байжээ. Нэг өдөр дотны найзындаа очив. Найз нь маш баян чинээлэг ба төрөл бүрийн сайхан хоолоор дайлав. Ядуу эр гэдсээ хагартал идээд, архинд согтоод нам унтаж орхив.



Найз нь гэнэт гадагш гарах ажилтай болж, ядуу зүдүү амьдарч байгаа найздаа санаа зовон найзынхаа энгэрт үнэлж баршгүй үнэт эрдэнэ хийгээд явав. Харин ядуу эр нам унтсан байсан тул түүнийг нь мэдсэнгүй.

Ядуу эр сэрээд найзынхаасаа явж, өөр нутагт очин өмсөх хувцас, идэх хоолны төлөө хүнд хүчир ажил хийн, олсон жоохон мөнгөндөө сэтгэл ханан амьдарч байв.

Нэг өдөр гэнэт нөгөө найзтайгаа дахин уулзав. Найз нь ядуу эрийг өмнөхтэйгөө адил ядуу зүдүү амьдарч байхыг хараад гайхаж, энгэрт нь эрдэнэ хийгээд явсан талаар хэлж, эрдэнийг авч харуулав. Ядуу эр ихэд баярлан түүнээс хойш гачигдаж дутагдах юмгүй сайхан амьдрах болжээ.



Тайлбар:

“Ядуу эр” нь хүмүүс биднийг, “дотны найз” нь Бурханыг илэрхийлнэ. “Үнэлж баршгүй үнэт эрдэнэ” гэдэг нь Нэг Хөлгөний сургаалыг илэрхийлнэ. Бурхан зовж шаналж байгаа хүмүүсийг аврахын төлөө янз бүрийн сургаал айлдах боловч тэр бүх сургаал нь хүмүүсийг адилхан бурханы түвшинд хүргэх сургаал байдаг. Хүмүүс бид харилцан адилгүй, өөр өөр замаар алхаж байгаа юм шиг харагддаг боловч угтаа бүгд Бурханы амь насыг хүртэж, нэгэн бүхэл агуу амийн ачаар амьдардаг. Үүнийг Нэг Хөлгөний сургаал гэдэг.

Өөрийн мэдэлгүй эрдэнийн чулуутай болсон гэдэг нь өөрөө мэдээгүй л болохоос биш бид хэдийн Бурханы гэгээрэлд хүрэх зам мөрөөр алхаж байгаа гэсэн үг.

Хүмүүс бид үүрд өөрчлөгдөхгүй нэгэн хэвийн оршихуй биш, нөхцөл байдлаас шалтгаалаад өөрчлөгдөж байдаг. Гэвч бодитоор нүдэнд харагдах өөрийнхөө дүрийг жинхэнэ өөрийгөө хэмээн андуурч, шунал хүсэлд автагдан зовлонгоор дүүрэн амьдардаг. Яг л энэ үлгэрт гарч байгаа ядуу эр шиг хэсэг хугацаанд амттай хоол, архи дарсанд сэтгэл ханах боловч нөхцөл өөрчлөгдөхөөр эргээд л өмнөх амьдрал руугаа шилжиж, үргэлж сэтгэл хангалуун байна гэж байддаггүй.

Тиймээс биднийг шунал хүсэлдээ автагдахгүй, сэтгэл хангалуун байгаасаа хэмээн Бурхан шүтэн барилдлагын сургаал айлддаг. Үүнийг үлгэрт өмсөх хувцас, идэх хоолны төлөө ажиллаж, жоохон мөнгөндөө сэтгэл ханан амьдарч байгаа хэсэг /Хоёр Хөлгөний амар амгалан түвшин/-ээр дамжуулан илэрхийлсэн байна. Найзтайгаа гэнэт дахин таарах үед найз нь үнэт эрдэнийн талаар хэлсэн гэдэг нь Бурхан бидэнд “та ч гэсэн бурханы гэгээрэлд хүрч чадна шүү дээ” хэмээн бурханы гэгээрэлд хүрнэ гэсэн баталгаа өгч байгаа утгатай.

Бурханаас үнэт эрдэнэ авлаа гэдэг нь зөвхөн өөрөө амар амгалан боллоо гэсэн үг биш. Энэ нь үнэлж баршгүй үнэтэй эрдэнэ буюу Нэг Хөлгөний сургаалыг өөрийн болгосон гэсэн үг юм. Энэ сургаалын ачаар бид алхаж байгаа зам мөр маань үнэндээ Бурханы зам мөр байсныг ойлгоно. Бурханы зам мөр гэдэг нь эргэн тойрныхоо хүмүүсийн аз жаргалын төлөө хичээдэг зам мөр /бодисадвагийн зам мөр/-ийг хэлнэ. Ингэж амьдрах нь үнэндээ Бурханы амь насыг хүртсэн бидний жинхэнэ амьдралын мөн чанар юм. Үнэт эрдэнэ өөрт байгааг мэдэх төдийд л бид одоо байгаа газартаа эргэн тойрноо гэрэлтүүлэх гэрэл гэгээ болж чадна. Яагаад гэвэл гялалзсан үнэт эрдэнэ бидний дотор байгаа билээ.

Чюүо эрдэм шинжилгээний институт



Тайлбарт Нивано Никкёогийн «Цагаан Лянхуа Сударын шинэ тайлбар» болон «Лянхуан Гурамсан Сударын шинэ тайлбар» номыг ашигласан болно.



Мэндчилгээ бол бурханлаг чанарт мөргөх үйл

Эртээд Хаконэгийн уламжлалт марафон гүйлтийн тэмцээнд 4 жил дараалан түрүүлсэн Аояма Гакүин их сургуулийн гүйлтийн албаны ахлагч Үчияма багштай уулзсан юм. Тамирчдыг хөгжүүлэхэд мэдээж хэрэг сайн рекорд үзүүлэхийг шаарддаг боловч түүнээс илүү хүнлэг чанар чухал байдаг хэмээн ярьсан.


Мөн тэд “мэндчилэх, тайлсан гутлаа зэрэгцүүлж тавих, дотуур байрныхаа эргэн тойрныг цэвэрлэх” гэсэн дүрмийг бодож олон хэрэгжүүлж байгаа гэсэн. Дээрх зүйлүүдийг дахин дахин хийснээр нэгнийгээ бодох сэтгэл төлөвшиж, багаараа ажиллаж чаддаг болсон болов уу.

Бид ч гэсэн “өдөр тутам хэрэгжүүлэх гурван үйл”-ээр дамжуулж мэндчилэхийн чухлыг суралцдаг билээ. Дээрх уулзалтаар дамжуулж мэндчилэхийн чухлыг дахин мэдэрсэн юм.

4 сар болохоор 1-р ангийн хүүхдүүдийн цангинасан мэндчилгээ энд тэндгүй сонсогддог. Жирийн л нэг өдөр тутмын мэндчилгээ хэдий ч, бид ч гэсэн нөгөө хүнийхээ төлөө бодож, чин сэтгэлээсээ мэндчилж байх хэрэгтэй.

Олон улсын хэлтсийн дарга

Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES

✉ Коментарите на нашиот е-весник Шан Заи се добродојдени. Ве молиме да ги пракате Вашите коментари на следната.
Интернет адреса: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Sugunami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
http://buddhistlearningcenter.org/

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX78269, USA
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Sacramento
Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai of Fort Myers

http://www.rkftmyersbuddhism.org/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
http://kosei-kai.blogspot.com/

Rissho Kosei-kai of Taichung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka, New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai